

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТОЛООЛОН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр

№ 24/32

Улаанбаатар хот

Нэмэлт гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Голомт банкнаас авсан Зээлийн гэрээний хугацааг энэхүү тогтоолын хавсралт №1-д заасан нөхцөлийн хүрээнд сунгахаар шийдвэрлэсүгэй.
2. Голомт банктай энэхүү тогтоолын хавсралт №1-д заасан нөхцөлийн дагуу Нэмэлт зээлийн гэрээ байгуулах, гарын үсэг зурж баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд байгуулсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, холбогдох бусад арга хэмжээ авах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. Голомт банктай байгуулсан Зээлийн гэрээ, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийн гэрээний хэрэгжилт, зээл ашиглалт болон холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр

№ 24/33

Улаанбаатар хот

Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 24/05 тоот тогтоол, ТУЗ-ийн 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор “М банк”-наас энэхүү тогтоолын хавсралт №1-д заасан нөхцөлийн хүрээнд зээл авахаар шийдвэрлэсүгэй.
2. “М банк”-тай энэхүү тогтоолын хавсралт №1-д заасан нөхцөлийн дагуу Зээлийн гэрээ болон Барьцааны гэрээ байгуулах, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд байгуулсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, холбогдох бусад арга хэмжээ авах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. “М банк”-тай байгуулсан Зээлийн болон Барьцааны гэрээний хэрэгжилт, зээл ашиглалт болон холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР